

## **АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2015 он)**

**Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний төвийн цахилгааны тэжээлийн системд гэмтэл гарсан ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан тухай;**

**ЗӨВЛӨМЖ 2015-02/01.** /Иргэний нисэхийн ерөнхий газар-НХҮА/

Орон нутагт ажиллаж байгаа нислэгийн удирдагч, мэдээллийн ажилтан нарт “Нислэгийн мэдээллийн эмхтгэл” ашиглах, нислэгийн аюулгүй өндрийн талаар сургалт зохион байгуулах.

**ЗӨВЛӨМЖ 2015-02/02.** /Иргэний нисэхийн ерөнхий газар-НХҮА/

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба өөрийн мэргэжилтнийг ашиглан бүсийн болон аэродромын нислэгийн удирдагч нарт тогтмолжсон нислэгийн ярианы (фразологи) хэллэгийн сургалтыг ЗЦ-172, annex 10, олон улсын иргэний нисэхийн байгууллагын баримт бичиг 9432, 4444 болон НХҮҮАЕЖ-ын хүрээнд зохион байгуулж, комисс томилон шалгалт авч технологич ажиллагааг жигдрүүлэн ААЧБХ-ийн зүгээс хяналт тавих хугацааг богиносгож чанаржуулах.

**Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны сургалтын талаар;**

**ЗӨВЛӨМЖ 2015-03/03.** /Иргэний нисэхийн ерөнхий газарт /

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Механик Тээврийн Сургуулийн агаарын хөлгийн инженерийн сургалтын хөтөлбөрийг Чикагогийн Конвенцийн Хавсралт 1, Doc 7192 /Training Manual D-1/ баримт бичиг болон “Иргэний нисэхийн багц дүрэм” ИНД 66-ийн Зөвлөмжийн цуврал АС66-ийн шаардлагад нийцүүлэн баталгаажуулж “Иргэний нисэхийн тухай” Монгол Улсын хуулийн 11.2.12 дах заалт, “Иргэний нисэхийн багц дүрэм” ИНД 66-ийн 66.53-ийн 4.1 дэх заалтуудыг үндэслэн, ИНД141-ийн дагуу тус сургуулийг 2016 оны 5 сард багтаан гэрчилгээжүүлэх.

**ЗӨВЛӨМЖ 2015-03/04.** /Агаарын тээврийн байгууллагуудад/

Чикагогийн Конвенцийн Хавсралт 1, Doc 7192 /Training ManualD-1/ баримт бичиг, “Иргэний нисэхийн багц дүрэм” ИНД 66-ийн зөвлөмжийн цуврал АС66-ийн дагуу цогц /суурь/ сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдаагүй “Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтан” –ийн үнэмлэх эзэмшигчдэд үйл ажиллагааг нь хязгаарлахгүйгээр ажлын байран дээр нь тусгай нэмэлт хөтөлбөрийг боловсруулж, ИНД141 дүрмээр зөвшөөрөгдсөн байгууллагад сургалт зохион байгуулан, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж эрхийг нь баталгаажуулах.

**ЗӨВЛӨМЖ 2015-03/05.** /ШУТИС-Механик Тээврийн Сургуульд/

Агаарын хөлгийн инженерийг сургаж байгаатай холбогдуулан Монгол Улс нэгдэн орсон Чикагогийн Конвенцийн Хавсралт 1, Doc 7192 /Training Manual D-1/ баримт бичиг болон “Иргэний нисэхийн багц дүрэм” ИНД 66-ийн зөвлөмжийн цуврал АС 66-ийн шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөрөө хийж, сургалтын байгууллагаа Иргэний нисэхийн ерөнхий газраар “Иргэний нисэхийн багц дүрэм”-ийн ИНД 141-ийн хүрээнд 2016 оны 5 дугаар сарын дотор баталгаажуулах.

**Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн сургалтын талаар;**

**ЗӨВЛӨМЖ 2015-04/06.** /Иргэний нисэхийн ерөнхий газарт /

Иргэний нисэхийн багц дүрэм ИНД 65, түүний зөвлөмжийн цувралыг Чикагогийн Конвенцийн Хавсралт 1-д нийцүүлэн сайжруулж хэрэгжүүлэх, Чикагогийн Конвенцийн Хавсралт 1-ийн 4.4.1.2, ICAO-ын Doc 7192 “Training Manual Part A-1 General Considerations” and “D-2 Air Traffic Controller”, ATC training guidance Doc 9683 “Human Factors Training Manual” , сургалтын хөтөлбөр, ICAO-ын Doc 9426 “ATS Planning Manual”-ийн 3.2 Initial Training-ийн заалтын дагуу сургалтын хөтөлбөрийн хугацааг бүрэн хангасан сургалтаар нислэгийн хөдөлгөөний удирдагчийн цогц, суурь сургалтыг зохион байгуулах, цаашид “Нислэгийн хөдөлгөөний удирдагч”-ийг /ICAO-ын Doc 9379 “Manual of Procedures for Establishment and Management of a State’s Personnel Licensing System” – ийн дагуу боловсруулан заавраар үнэмлэх, гэрчилгээ олгох.

**ЗӨВЛӨМЖ 2015-04/07.** /Иргэний нисэхийн ерөнхий газрын-НХУГ /

Зөвлөмж 201504/06 –т заагдсан суурь сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдаагүй “нислэгийн хөдөлгөөний удирдагч”-ийн үнэмлэх эзэмшигчдийн эрхийг хязгаарлахгүйгээр ажлын байран дээр нь нэмэлт хөтөлбөрийн боловсруулж “иргэний нисэхийн багц дүрэм” ИНД 141-ийн зөвшөөрөгдсөн байгууллагад сургалт зохион байгуулан, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж 2016 оны 6 дугаар сарын 1-ний дотор багтаан эрхийг нь баталгаажуулах.

**Агаарын хөлгийн бичлэгийн төхөөрөмжийн ашиглалтын талаар;**

**ЗӨВЛӨМЖ 2015-04/08.** /Иргэний нисэхийн ерөнхий газар, Агаарын тээврийн компаниуд/

Иргэний нисэхийн дүрэм, Техник үйлчилгээний хөтөлбөрт FDR, CVR-ийн бичлэгийн системийн ашиглалтын үед хийгдэх техникийн үзлэг шалгалт /inspection/ , тохируулга /calibration/-ыг Чикагогийн Конвенцийн Хавсралт 6, түүний Part I, App 9-ийн 7 ба Part III, App 5-ын 6 дугаар зүйлд тус тус заасны дагуу тусгаж хэрэгжүүлэх.

**ЗӨВЛӨМЖ 2015-04/09.** /Иргэний нисэхийн ерөнхий газарт/

Чикагогийн Конвенцийн Хавсралт 6, түүний Part I-ын 6.3-д Агаарын хөлгийн бичлэгийн FDR, CVR системд соронзон тууз /magnetic tape/-ийг 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс

хойш ашиглахыг хориглосон заалтын дагуу Аэромонголиа компанийн F50 маягийн JU8250, JU8251, JU8258 агаарын хөлгүүдийн ярианы бичлэгийн CVR системийн соронзон туузан төхөөрөмж, Тэнгэрийн улаач шинэ компанийн L410 УВП, JU2032 агаарын хөлгийн бичлэгийн БУР-1-2Г системийн соронзон туузан төхөөрөмжийг уг шаардлагад нийцүүлэн солих.

Мөн Чикагогийн Конвенцийн Хавсралт 6, түүний Part III -ын 4.3-д Агаарын хөлгийн бичлэгийн FDR, CVR системд соронзон тууз ба утас /magnetic tape and wire/-ийг 2016 он ы 1 д үгээр сарын 1 -ээс хойш ашиглахыг хориглосон заалтын дагуу МАК-ын Ми-8 маягийн JU6600, JU6601 агаарын хөлгүүдийн ярианы бичлэгийн П-503Б төхөөрөмжийг уг шаардлагад нийцүүлэн тус тус солих.

**“Эйр Чайна” компанийн CCA902/B737 агаарын хөлөг тасалдсан хөөрөлт үйлдсэн тухай;  
ЗӨВЛӨМЖ 2015-05/10. /Иргэний нисэхийн ерөнхий газар-НХУГ/**

Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт хийх, мэдээлэх талаар “Аэродром, ойртолтын удирдлагын байрны үйл ажиллагааны заавар”-т агаарын хөлгийн тооцоот цаг, агаарын замын байдал зэргийг харгалзсан аргачлалыг тусгасан (ATC clearance) нэмэлтийг Зөвлөмжийн цуврал 172-01, Annex 10, Doc 9432, Doc 4444-ын холбогдох заалтын дагуу оруулах.

**“Тэнгэрийн Улаач Шинэ” ХХК-ны JU2032/L410 агаарын хөлгийн зүүн хөдөлгүүрийн турбины бүтэц гэмтсэн ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан тухай;  
ЗӨВЛӨМЖ 2015-05/11. /Иргэний нисэхийн ерөнхий газарт/**

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч нарт тавигдах мэдлэг, туршлагын шаардлагыг Олон улсын Иргэний Нисэхийн байгууллага ИКАО-ын Doc9760-ын 4-р, Doc8335-ын 6-р бүлгүүдэд тавигдсан минимум шаардлагатай нийцүүлэн мөрдөж ажиллах Doc9760-ын 4-р бүлэг. Үүнд:

- Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээжилт, хяналтын байцаагч нь шалгуулах этгээдтэй дүйцэхүйц эсвэл давуу мэдлэг, туршлагатай байх
- Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэхтэй байх
- Агаарын хөлөг, түүний эд ангийн техник үйлчилгээний дараа нислэгт тэнцэх чадварыг гэрчилгээжүүлж байсан туршлагатай байх
- Агаарын хөлгийг техник үйлчилгээнээс гаргаж байсан туршлагатай байх

Doc8335-ын 6-р бүлэг. Үүнд:

- Нислэгийн үйл ажиллагааны байцаагч нь шалгуулах этгээдтэй дүйцэхүйц эсвэл давуу мэдлэг, туршлагатай байх

- Нислэгийн үйл ажиллагааны байцаагч нь агаарын хөлгийн даргаар 5000 цагаас багагүй ниссэн байх
- Нислэгт шалгах байцаагч нь тухайн агаарын хөлөг эсвэл ижил нислэгийн үзүүлэлттэй агаарын хөлгийн эрхтэй, зохих нислэгийн чиглэлд ниссэн туршлагатай байх
- Нисгэгчийг шугамын болон үнэмлэх баталгаажуулах нислэгт шалгах байцаагч нь агаарын тээврийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх
- Нислэгийн үйл ажиллагааны байцаагч болох этгээд өмнө нь нислэгийн үйл ажиллагааны удирдлагад агаарын тээврийн нисгэгч болон итгэмжлэгдсэн шалгагч эсвэл багш нисгэгч байсан байх г.м.

**ЗӨВЛӨМЖ 2015-05/12. /Иргэний нисэхийн ерөнхий газарт/**

ИНД135 дүрмийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгчийн удирдах албан тушаалтны мэргэжлийн ур чадварт тавигдах ИНД119 Хавсралт Б-д заагдсан шаардлагыг иргэний нисэхийн олон улсын нийтлэг шаардлагад (NZR) нийцүүлэн дараах байдлаар өөрчлөх:

Б-2 Удирдах албан тушаалтны мэргэжил, дадлага туршлагын талаар ИНД-135-д тавигдах шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1/ Нислэгийн аюулгүй ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан нь:

1.1 нисгэгчийн мэргэжилтэй байх коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй, хэрэв шаардлагатай бол хэрэглэлийн нислэгийн зэрэглэлтэй,

1.2 сүүлийн 6 жилийн 3-аас доошгүй жилд нь аль нэг маягийн ижил ангиллын агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн дадлага туршлагатай байна.

2/ Техникийн үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан нь:

2.1 агаарын хөлгийн их бие, хөдөлгүүрийн болон авионикийн инженер,

2.2 агаарын хөлгийн техник үйлчилгээг төлөвлөх, удирдах, ТҮ-ний гүйцэтгэлийг хянах ажлын дадлага туршлагатай /энэ чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан/

2.3 сүүлийн 6 жилийн 3- аас доошгүй жилд нь аль нэг маягийн ижил ангилалын агаарын хөлгийн техник үйлчилгээнээс гаргах ажил гүйцэтгэсэн дадлага туршлагатай;

3/ Нисэх багийн гишүүдийн сургалт, дадлага хариуцсан удирдах албан тушаалтан нь:

3.1 нисгэгчийн мэргэжилтэй байх коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй, хэрэв шаардлагатай бол хэрэглэлийн нислэгийн зэрэглэлтэй байх,

3.2 сүүлийн 6 жилийн 3 -аас доошгүй жилд нь аль нэг маягийн ижил ангилалын агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн дадлага туршлагатай, даргаар нисдэг байх

**ЗӨВЛӨМЖ 2015-05/13. /Иргэний нисэхийн ерөнхий газарт/**

ИНД 39.52(а)2/-д 5700кг-аас доош жинтэй агаарын хөлөгт зохион бүтээгч улсын НТЧ удирдамжийг биелүүлэхгүй байж болохоор заасныг Олон улсын иргэний нисэхийн

байгууллага ИКАО-ын Хавсралт 8-ын 4.2.3 “State of Registry” бүлгийн шаардлагатай нийцүүлэн зохион бүтээгч улсын НТЧ удирдамжийг заавал хэрэгжүүлэх болгож нэн даруй өөрчлөх

**ЗӨВЛӨМЖ 201505/14.** /Иргэний нисэхийн ерөнхий газарт, Агаарын тээвэрлэгчдэд/

Агаарын тээвэрлэгчид ИНЕГ-тай хамтран Нислэгийн ашиглалтын зааврын хязгаарлалт /Limitations/, нислэгийн өмнөх бэлтгэл /Flight planning/, агаарын хөлгийн нислэгийн үзүүлэлт /Aircraft performance/ болон хөөрөлтийн үеийн аюулгүй ажиллагаа /FAA Take Off Safety Aid/ зэрэг сэдвүүдийг хамарсан сургалтыг хүчинтэй жин төвлөрөлтийн хуудас /validated weight & balance sheet/ ашиглан нисгэгч, диспетчер нарт 2015.07.01-ээс өмнө зохион байгуулах.

**“Томас Эйр” ХХК-ны JU1911/PC6 агаарын хөлөг хөөрөлт үйлдэхээр гүйх үедээ зурваснаас гарсан ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан тухай;**

**ЗӨВЛӨМЖ 2015-08/15.** /Иргэний нисэхийн ерөнхий газарт/

Нисгэгч, инженер техникийн ажилтан нь агаарын хөлгийн техникийн бичиг баримт бичигдсэн хэлээр уншиж ойлгох чадвартай байх тухай шаардлагыг ИНД61, 66 дугаар дүрмүүдэд тодорхой тусгах

**ЗӨВЛӨМЖ 2015-08/16.** /Иргэний нисэхийн ерөнхий газарт/

Агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээг олгохдоо тухай хөлгийг Монгол улсад ашиглах үйл ажиллагааны хязгаарлалт, нисэх бүрэлдэхүүн, инженер техникийн ажилтны маягийн сургалт, ур чадварын хяналт, гэрчилгээжүүлэлтэнд тавигдах шаардлагыг тодорхойлсон үйл ажиллагааны шинжилгээ (operational evaluation) хийдэг болох

**ЗӨВЛӨМЖ 2015-08/17.** /Иргэний нисэхийн ерөнхий газарт/

Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтын байгууллагыг гэрчилгээжүүлэх иргэний нисэхийн дүрмийг нэн даруй гаргаж хэрэгжүүлэх (EASA Part M)

**НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА**